



ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/19

Баян-Өндөр сум

Мөнгөн дэмжлэг үзүүлэх
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 07-ний өдрийн А/321 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн аварга, ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д. Дашбаатар)-д үүрэг болгосугай.

3. Мөнгөн дэмжлэгт зарцуулагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг зохих журмын дагуу нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Б. Золзаяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, СПОРТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА *Э. Лхамсүрэнбаатар* Э. ЛХАМСҮРЭНБААТАР



Биеийн тамир, спортын газрын даргын
 2026 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн
 А/16 дугаар тушаалын хавсралт

ТЭМЦЭЭН, УРАЛДААНЫ МӨНГӨН ДЭМЖЛЭГТ ЗАРЦУУЛАГДАХ
 ТӨСӨВ

№	Шийдвэрийн нэр, дугаар, огноо	Спортын төрөл	Зардлын нэр	Хүний тоо		Нэг бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
				Тамирчин	Дасгалжуулагч		
д/д	2	3	4	5	6	7	8
1	Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/321 дүгээр захирамж	БНХАУ-д зохион байгуулагдах Пауэрлифтингийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн	Оролцох зардал	6	-	500,000	3,000,000
2		Узбекистан улсад зохион байгуулагдах Даамны ази тивийн аварга шалгаруулах тэмцээн	Оролцох зардал	7	1	500,000	4,000,000
3		Польш улсад зохион байгуулагдах Хэвтээ шахалтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн	Оролцох зардал	1	-	1,000,000	1,000,000
Төсвийн нийт дүн							8,000,000

----oOo----